

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ПРОТОКОЛ

2020 оны 4-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот, ЛОББИ төв

“Дархан гурил тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4-р сарын 30-ны өдрийн 17.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, ЛОББИ төвийн хурлын зааланд эхлэв.

Хурлын даргаар томилогдсон Ш.Энхтөр хурлыг удирдан явуулав.

Хурлын дарга Ш.Энхтөр тооллогын комиссын бүрэлдхүүн Д.Мөнхцэцэг, Б.Нямдэлгэр нарыг танилцуулж, тооллогын комиссын даргаар томилогдсон Б.Батбаяр нь Дархан-Уул аймаг, Гурилын үйлдвэрийн байранд ажил гарч хот руу ирэх боломжгүй болсонг танилцуулаад тооллогын комиссын даргын үүргийг тооллогын комиссын гишүүн Д.Мөнхцэцэг гүйцэтгэнэ гээд хурлын ирцийн талаар мэдээлэл хийхийг хүслээ.

Д.Мөнхцэцэг: Хуралд нийт 614603 хувьцаа эзэмшигчдээс 550464 ширхэг хувьцааг эзэмшигчид буюу нийт хувьцааны 89,6%-ийг эзэмшигчид ирсэн байна.

Хурлын дарга Ш.Энхтөр: Компанийн тухай хууль болон “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5.5.21-д зааснаар ирц хүчин төгөлдөр тул хурлыг хуралдуулахаар шийдвэрлэв.

Хурлын дарга Ш.Энхтөр: Ээлжит хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Хувьцаа хуваах, нэмж гаргах ажлын явцыг хэлэлцэх, дүгнэх
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах асуудлууд байгаа.

Оролцогчдын 100% саналаар хэлэлцэх асуудлыг батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хурлын дэгийг уншиж танилцуулав. /дэг хавсаргасан/

Хурлын дэгийг 100% санал нэгтэй батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал “Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт”-ийг хэлэлцэж батлах асуудал байгаа. Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт”-ийг танилцуулав.

Дүгнэлтийг хавсаргалаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Дүгнэлттэй холбоотой асуулт, санал байна уу?

С.Намсрайжав: Хэлэлцэх асуудлаа бүгдийг сонсож танилцчихаад санал, асуултаа нэгтгэж тавих саналтай байна.

Хуралд оролцогцогсод 100% дэмжлээ.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хувьцаа хуваах, нэмж гаргах ажлын явцыг хэлэлцэх, дүгнэх асуудал байгаа. Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр танилцуулна.

Танилцуулгыг хавсаргалаа.

С.Намсрайжав: Хувьцаа эзэмшигч Д.Балдан-Очир 2019 оны 12 дугаар сараас гадны хөрөнгө оруулах сонирхолтой хуулийн этгээд, иргэдтэй ажиллаж байгаа. 2020 оны 2 сарын 28 өдөр ОХУ яваад дэлхий нийтийн цар хорионд ороод ирж чадахгүй байна. Хөрөнгө оруулахыг сонирхогч нь Монгол улсад ирж, компанийн үйл ажиллагаа, бодит байдалтай танилцаад тодорхой саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах зорилготой байсан. Хорио цээрээс болоод тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.

Ш.Энхтөр: Хувьцаа хуваах асуудал жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нөлөөлөхгүй, иймд асуудлаа үе шаттай шийдээд явах шаардлагатай байна. Гүйцэтгэх захирал хувьцаа хуваах асуудлыг шийдвэрлүүлэх талаар чармайлттай ажиллах хэрэгтэй.

Хурлын дарга Ш.Энхтөр: Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах асуудлаа хэлэлцье. Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр танилцуулна.

ТУЗ-ийн шийдвэрийг Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр танилцуулсан. Шийдвэрийг хавсаргав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг сонсож танилцлаа. Асуулт, саналдаа оръё.

Хувьцаа эзэмшигч А.Базар: Надад 2 асуулт байна. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн албан бичигт дурдагдсан өр төлбөрийн талаар сонирхож байна, 2-т гадны хөрөнгө оруулагчийн талаар сонслоо, дотоодын хөрөнгө оруулагч байвал зөвшөөрөх үү.

Ш.Энхтөр: Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нэхэмжлэлтэй “Дархан гурил тэжээл” ХК-ийг хариуцагчаар татсан 2009 онд үүссэн маргаан байгаа. Нэхэмжлэгч тал 7,0 орчим тэрбум төгрөг нэхэмжилдэг, манай компани сөрөг нэхэмжлэл гаргасан хэрэг, шүүхийн хяналтын шатанд байгаа ойролцоогоор 2-3 тэрбум төгрөгийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй.

С.Намсрайжав: Компанийн хөрөнгө оруулалтын асуудал нээлттэй байгаа. Гадны хөрөнгө оруулагчийн оруулах хөрөнгийн дүн, тавих нөхцөл саналыг эхний ээлжинд шийднэ. Дотоодын хөрөнгө оруулагчийн хувьд нээлттэй.

Ш.Энхтөр: Өөр асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Та бүхэнд хурлын хэлэлцсэн асуудал бүхий саналын хуудас өгсөн байгаа. Саналаа өгнө үү.

Тооллогын комиссын даргын үүрэг гүйцэтгэгч Д.Мөнхцэцэг саналын хуудсуудыг нэгтгээд тогтоолоо танилцуулна.

Д.Мөнхцэцэг тооллогын комиссын тогтоолуудыг танилцууллаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцсэн асуудлыг дүгнэж хурлын тогтоолын төслүүдийг танилцууллаа.

Хуралд оролцогсод 100%-ийн саналаар батлав.

Ш.Энхтөр: Дархан гурил тэжээл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хурлын материалаа Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Улсын бүртгэлийн албанд гаргаж, бүртгүүлэх ажлыг ТУЗ, гүйцэтгэх удирдлагад даалгаж байна. Хуралд оролцсон та бүхэнд талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

Хурал: 2020 оны 4-р сарын 30-ны 18.00 цагт өндөрлөв.

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн



Ш.Энхтөр

С.Намсрайжав